

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, сангийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2024/381/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024он	Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Аккаунт траст аудит ХХК-ийн захирал П.Наранцэцэг Утас: 99130778 Цахим хаяг: acctrust.audit@gmail.com Ахлах аудитор Ч.Замбага Утас: 99127118 Аудитор: П.Саранчимэг Утас: 89986879
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	20
4.1 Ерөнхий зүйл.....	20
4.2 Материаллаг байдал	20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	20
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	21
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	21
4.5.1 Завсрын аудитын талаар	21
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	21
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	22
АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДҮЗ	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И мэйл: ub@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn

2024.02.23 № 137
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА
Л.ОЧИРБАЛ ТАНАА

Баянгол дүүргийн нийгмийн даатгалын
хэлтэс, сангийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан,
гэрчилгээг хүргүүлж байна.

Хавсралт 22. хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

002033024

D:\Desktop\2024\Word\Явсан бичиг\2024.02.23.BGD.NDH.A5.docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024. 02. 23 № 138
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ
ДҮҮРГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА
Л.ОЧИРБАЛ ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус хэлтсийн талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 56 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 98 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

М.ЭРДЭНЭЖАРГАЛ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
	НИЙТ ДҮН	-	-
	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	112,951,915,588.20	112,754,383,722.61
	МӨНГӨН ХӨРӨНГӨ	24,035,894,748.05	31,621,232,542.00
	Банкинд байгаа бэлэн мөнгө	24,035,894,748.05	31,621,232,542.00
	Төгрөг	24,035,894,748.05	31,621,232,542.00
31211+0	Төрийн сангийн харилцах	813,716.14	47,417,889.94
31213	Арилжааны банк дахь харилцах	24,035,081,031.91	31,573,814,652.06
	АВЛАГА	88,894,816,985.65	81,113,586,067.11
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	43,033,642,501.37	49,422,250,471.45
33300	Татаас, санхүүжилтийн авлага	45,498,316,081.00	31,352,212,241.92
	Бусад авлага	362,858,403.28	339,123,353.74
33510	Байгууллагаас авах авлага	362,858,403.28	339,123,353.74
	БАРАА МАТЕРИАЛ	21,203,854.50	19,565,113.50
	Хангамжийн материал	21,203,854.50	19,565,113.50
35410	Бичиг хэргийн материал	5,353,335.00	1,632,340.00
35420	Аж ахуйн материал	11,353,950.00	13,433,900.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,807,800.00	3,807,800.00
35470	Бусад хангамжийн материал	688,769.50	691,073.50
	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,157,609,398.78	2,076,701,615.44
	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,157,609,398.78	2,076,701,615.44
	Биет хөрөнгө	2,121,403,880.00	2,040,829,171.71
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,183,034,461.99	2,183,034,461.99
39202	Хуримтлагдсан элэгдэл	-231,185,518.08	-281,984,819.64
39203	Авто-тээврийн хэрэгсэл	12,210,000.00	12,210,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-2,442,000.00	-4,884,000.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	185,009,158.00	161,168,907.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	-64,413,755.86	-61,750,027.94
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	182,103,850.00	140,316,311.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	-142,912,316.05	-107,281,661.80
	Биет бус хөрөнгө	36,205,518.78	35,872,443.73
39301	Програм хангамж	1,332,300.00	1,332,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-582,881.22	-915,956.27
39303	Бусад биет бус хөрөнгө	35,456,100.00	35,456,100.00
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	115,109,524,986.98	114,831,085,338.05
	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,747,782,946.35	3,805,189,857.94
	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,747,782,946.35	3,805,189,857.94

Баянгол дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс, сангийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	Өглөг	312,254,201.00	734,193,422.38
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	312,254,201.00	734,193,422.38
	Урьдчилж орсон орлого	1,435,528,745.35	3,070,996,435.56
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	1,435,528,745.35	3,070,996,435.56
	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	113,361,742,040.63	111,025,895,480.11
	Засгийн газрын хувь оролцоо	1,115,089,750.85	1,115,089,750.85
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	776,548,011.93	776,548,011.93
	Хуримтлагдсан үр дүн	112,246,652,289.78	109,910,805,729.26
51210	Өмнөх үеийн үр дүн	112,246,652,289.78	112,092,559,299.63
51220	Тайлант үеийн үр дүн	-	-2,181,753,570.37
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	338,541,738.92	338,541,738.92
	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	115,109,524,986.98	114,831,085,338.05

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

		/төгрөгөөр/	
Код	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
	НИЙТ ДҮН	-	-
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	436,204,781,162.16	542,431,309,588.84
	ТАТВАРЫН ОРЛОГО	390,845,394,910.24	484,934,174,897.82
	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	390,845,394,910.24	484,934,174,897.82
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	271,432,617,182.03	337,113,540,385.33
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	28,712,547,264.34	35,617,469,900.83
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	23,790,411,178.05	29,190,524,947.62
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	5,700,013,821.26	7,067,359,918.82
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	61,209,805,464.56	75,945,279,745.22
	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	391,476,258.92	859,797,316.52
	Нийтлэг татварын бус орлого	391,476,258.92	859,797,316.52
120002	Хүүгийн орлого	1,089,838.42	344,354,684.29
	Төсөвт байгууллагын өөрийн орлого	186,226,485.50	261,187,177.23
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	175,097,035.50	242,525,870.03
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	223,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	10,906,450.00	18,661,307.20
120009	Бусад орлого	204,159,935.00	254,255,455.00
	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	44,967,909,993.00	56,637,337,374.50
	Улсын төсвөөс	40,208,166,314.00	50,026,056,068.50
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	40,208,166,314.00	50,026,056,068.50
	Төсвийн захирагчдаас	3,428,742,179.00	4,697,962,606.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,428,742,179.00	4,697,962,606.00
	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,331,001,500.00	1,913,318,700.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,296,477,300.00	1,913,318,700.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	34,524,200.00	-
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	470,357,739,494.96	544,613,063,159.21
	УРСГАЛ ЗАРДАЛ	470,357,739,494.96	544,613,063,159.21
	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,299,318,198.11	1,902,643,877.83
	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	965,793,095.00	1,467,832,117.99
210101	Үндсэн цалин	616,452,103.08	856,862,174.99
210102	Нэмэгдэл	149,117,567.82	254,575,027.00
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	111,450,840.30	169,007,282.00
210104	Урамшуулал	88,772,583.80	187,387,634.00
	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	123,303,497.12	185,861,547.00
210201	Тэтгэврийн даатгал	85,233,421.98	126,890,398.51
210202	Тэтгэмжийн даатгал	9,660,632.93	14,928,909.27
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,670,828.47	12,021,716.98
210204	Ажилгүйдлийн даатгал	1,843,519.40	2,758,786.90
210205	Эрүүл мэндийн даатгал	18,895,094.34	29,261,735.34
	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,904,422.00	31,520,925.80
210301	Гэрэл, цахилгаан	9,889,719.00	11,622,313.62
210302	Түлш, халаалт	5,676,518.00	13,251,913.18
210303	Цэвэр, бохир ус	10,338,185.00	6,646,699.00
	Хангамж, бараа материалын зардал	34,654,031.12	52,187,836.50
210401	Бичиг хэрэг	14,962,065.00	19,060,292.00
210402	Тээвэр, шатахуун	3,734,400.00	1,420,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,071,325.12	6,178,394.50

Баянгол дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс, сангийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,220,000.00	720,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,666,241.00	24,808,450.00
	Эд хогшил, урсгал засварын зардал	26,742,000.00	31,632,550.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,242,000.00	8,922,010.00
210604	Урсгал засвар	24,500,000.00	22,710,540.00
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,505,004.00	33,489,810.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,914,000.00	6,114,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,100,000.00	12,200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	900,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	59,984.00	59,984.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	99,000.00
210807	Газрын төлбөр	56,500.00	56,500.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	11,115,140.00	11,891,130.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	9,359,380.00	3,068,696.00
	Бараа үйлчилгээний бусад зардал	87,416,148.87	100,119,090.54
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,954,000.00	550,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	85,462,148.87	99,569,090.54
	УРСГАЛ ШИЛЖИЛЭГ	469,058,421,296.85	542,710,419,281.38
	Бусад урсгал шилжүүлэг	255,402,685,632.24	319,451,615,682.03
		255,289,988,135.24	319,425,482,088.03
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	14,066,074.00	7,676,430.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	95,688,931.00	18,457,164.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшуулал	2,942,492.00	-
	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	213,655,735,664.61	223,258,803,599.35
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	213,655,735,664.61	223,258,803,599.35
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	-34,152,958,332.80	-2,181,753,570.37
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	-34,152,958,332.80	-2,181,753,570.37

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Код	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он /төгрөгөөр/
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	468,205,539,833.96	552,361,088,738.09
	ТАТВАРЫН ОРЛОГО	379,174,292,665.78	479,383,308,134.44
	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	379,174,292,665.78	479,383,308,134.44
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	263,325,130,560.34	333,322,345,573.86
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	27,874,428,703.64	35,243,570,085.37
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	23,064,101,209.78	28,827,944,021.71
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	5,545,712,600.33	6,935,916,043.49
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	59,364,919,591.69	75,053,532,410.01
	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	448,071,762.18	928,010,897.65
	Нийтлэг татварын бус орлого	448,071,762.18	928,010,897.65
120002	Хүүгийн орлого	1,089,838.42	309,757,650.97
	Төсөвт байгууллагын өөрийн орлого	446,981,923.76	618,253,246.68
120004 1+1200 045	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	446,758,923.76	618,253,246.68
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	223,000.00	-
	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	88,583,175,406.00	72,049,769,706.00
	Улсын төвлөрсөн төсвөөс	-	65,444,845,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	65,444,845,400.00
	Төсвийн захирагчдаас	87,252,173,906.00	4,691,605,606.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	83,917,352,900.00	-
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,334,821,006.00	4,691,605,606.00
	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,331,001,500.00	1,913,318,700.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,296,477,300.00	1,913,318,700.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	34,524,200.00	-
	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	472,262,656,879.45	544,775,750,944.14
	УРСГАЛ ЗАРДАЛ	472,262,656,879.45	544,775,750,944.14
	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,205,336,187.12	1,795,079,046.29
	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	965,793,095.00	1,467,832,117.99
210101	Үндсэн цалин	616,452,103.08	856,862,174.99
210102	Нэмэгдэл	149,117,567.82	254,575,027.00
210103	Унаа хоолны Хөнөлөлт	111,450,840.30	169,007,282.00
210104	Урамшуулал	88,772,583.80	187,387,634.00
	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	125,744,511.00	185,861,547.00
210201	Тэтгэврийн даатгал	85,707,473.00	126,890,398.51
210202	Тэтгэмжийн даатгал	10,015,189.00	14,928,909.27
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,029,346.00	12,021,716.98
210204	Ажилгүйдлийн даатгал	1,975,189.00	2,758,786.90
210205	Эрүүл мэндийн даатгал	20,017,314.00	29,261,735.34
	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,904,422.00	31,520,925.80
210301	Гэрэл, цахилгаан	9,889,719.00	11,622,313.62
210302	Түлш, халаалт	5,676,518.00	13,251,913.18
210303	Цэвэр, бохир ус	10,338,185.00	6,646,699.00

Баянгол дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс, сангийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	Хангамж, бараа материалын зардал	32,483,535.12	46,410,791.50
210401	Бичиг хэрэг	15,085,600.00	11,203,297.00
210402	Тээвэр, шатахуун	3,734,400.00	1,420,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,071,325.12	6,178,394.50
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,220,000.00	720,000.00
210406 +21040 7+2104 08	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,372,210.00	26,888,400.00
	Эд хогшил, урсгал засварын зардал	27,311,000.00	31,632,550.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,811,000.00	8,922,010.00
210604	Урсгал засвар	24,500,000.00	22,710,540.00
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,145,624.00	31,271,114.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,914,000.00	6,964,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,100,000.00	12,200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	900,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	59,984.00	59,984.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	99,000.00
210807	Газрын төлбөр	56,500.00	56,500.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	11,115,140.00	11,891,130.00
	Бараа үйлчилгээний бусад зардал	1,954,000.00	550,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,954,000.00	550,000.00
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	471,057,320,692.33	542,980,671,897.85
	Бусад урсгал шилжүүлэг	257,401,585,027.72	319,721,868,298.50
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	256,769,885,344.44	319,129,035,199.81
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	14,066,074.00	7,676,430.00
213205	Төрөөс иргэдэд үзүүлэх бусад тэтгэмж, урамшуулал	519,002,186.28	566,699,504.69
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	95,688,931.00	18,457,164.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшуулалж	2,942,492.00	-
	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	213,655,735,664.61	223,258,803,599.35
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	213,655,735,664.61	223,258,803,599.35
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	(4,057,117,045.49)	7,585,337,793.95
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(4,057,117,045.49)	7,585,337,793.95
ЭХ.ДТ(31)	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	28,093,011,793.54	24,035,894,748.05
ЭЦ.ДТ(31)	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	24,035,894,748.05	31,621,232,542.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
НИЙТ ДҮН	-	-	-	-
2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	776,548,011.93	338,541,738.92	146,509,630,855.08	147,624,720,605.93
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(110,020,232.50)	(110,020,232.50)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	146,399,610,622.58	146,399,610,622.58
Тайлант үеийн үр дүн	-	-	(34,152,958,332.80)	(34,152,958,332.80)
2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	776,548,011.93	338,541,738.92	112,246,652,289.78	113,361,742,040.63
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(154,092,990.15)	(154,092,990.15)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	776,548,011.93	338,541,738.92	112,092,559,299.63	113,207,649,050.48
Тайлант үеийн үр дүн	-	-	(2,181,753,570.37)	(2,181,753,570.37)
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	776,548,011.93	338,541,738.92	109,910,805,729.26	111,025,895,480.11

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Төсөв	Тайлант он	Зөрүү	Хувь
1	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	326,774,849,800.00	320,950,247,840.10	(5,824,601,959.90)	98.2
2	УРСГАЛ ЗАРДАЛ	326,774,849,800.00	320,950,247,840.10	(5,824,601,959.90)	98.2
3	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,883,444,300.00	1,795,079,046.29	(88,365,253.71)	95.3
4	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,515,727,200.00	1,467,832,117.99	(47,895,082.01)	96.8
5	Үндсэн цалин	835,884,300.00	856,862,174.99	20,977,874.99	102.5
6	Нэмэгдэл цалин	261,228,100.00	254,575,027.00	(6,653,073.00)	97.5
7	Унаа хоолны Хөнгөлөлт	197,054,000.00	169,007,282.00	(28,046,718.00)	85.8
8	Урамшуулал	221,560,800.00	187,387,634.00	(34,173,166.00)	84.6
10	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	189,466,000.00	185,861,547.00	(3,604,453.00)	98.1
11	Тэтгэврийн даатгал	128,836,800.00	126,890,398.51	(1,946,401.49)	98.5
12	Тэтгэмжийн даатгал	15,157,300.00	14,928,909.27	(228,390.73)	98.5
13	ҮОМШӨ-ний даатгал	12,125,800.00	12,021,716.98	(104,083.02)	99.1
14	Ажилгүйдлийн даатгал	3,031,500.00	2,758,786.90	(272,713.10)	91.0
15	Эрүүл мэндийн даатгал	30,314,600.00	29,261,735.34	(1,052,864.66)	96.5
16	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,368,700.00	31,520,925.80	(17,847,774.20)	63.8
17	Гэрэл, цахилгаан	18,334,000.00	11,622,313.62	(6,711,686.38)	63.4
18	Түлш, халаалт	17,280,000.00	13,251,913.18	(4,028,086.82)	76.7
19	Цэвэр, бохир ус	13,754,700.00	6,646,699.00	(7,108,001.00)	48.3
21	Хангамж, бараа материалын зардал	56,004,800.00	46,410,791.50	(9,594,008.50)	82.9
22	Бичиг хэрэг	17,133,300.00	11,203,297.00	(5,930,003.00)	65.4
23	Тээвэр, шатахуун	2,339,400.00	1,420,700.00	(918,700.00)	60.7
24	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,577,100.00	6,178,394.50	(398,705.50)	93.9
26	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,235,000.00	720,000.00	(515,000.00)	58.3
27	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	28,720,000.00	26,888,400.00	(1,831,600.00)	93.6
32	Эд хогшил, урсгал засварын зардал	32,572,000.00	31,632,550.00	(939,450.00)	97.1
33	Багаж, техник, хэрэгсэл	9,466,000.00	8,922,010.00	(543,990.00)	94.3
36	Урсгал засвар	23,106,000.00	22,710,540.00	(395,460.00)	98.3
41	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,076,600.00	31,271,114.00	(6,805,486.00)	82.1
42	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,304,000.00	6,964,500.00	(1,339,500.00)	83.9
43	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	12,200,000.00	12,200,000.00	-	100.0
44	Даатгалын үйлчилгээ	900,000.00	-	(900,000.00)	-
45	Тээврийн хэрэгслийн татвар	97,000.00	59,984.00	(37,016.00)	61.8
47	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	99,000.00	99,000.00	-	100.0
48	Газрын төлбөр	175,000.00	56,500.00	(118,500.00)	32.3

Баянгол дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс, сангийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

49	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	16,301,600.00	11,891,130.00	(4,410,470.00)	72.9
51	Бараа үйлчилгээний бусад зардал	2,229,000.00	550,000.00	(1,679,000.00)	24.7
53	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,229,000.00	550,000.00	(1,679,000.00)	24.7
80	Бусад урсгал шилжүүлэг	324,891,405,500.00	319,155,168,793.81	(5,736,236,706.19)	98.2
81	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	324,846,135,500.00	319,129,035,199.81	(5,717,100,300.19)	98.2
83	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,430,800.00	7,676,430.00	(1,754,370.00)	81.4
86	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	35,839,200.00	18,457,164.00	(17,382,036.00)	51.5
107	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	326,774,849,800.00	470,546,271,693.25	143,771,421,893.25	144.0
110	Улсын төсвөөс санхүүжих	65,444,845,400.00	65,444,845,400.00	-	100.0
111	Улсын төсвөөс санхүүжих	65,444,845,400.00	65,444,845,400.00	-	100.0
118	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	261,330,004,400.00	404,633,444,118.59	143,303,439,718.59	154.8
119	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	261,330,004,400.00	404,633,444,118.59	143,303,439,718.59	154.8
123	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	467,982,174.66	467,982,174.66	
124	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	467,982,174.66	467,982,174.66	
130	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	24,035,894,748.05	24,035,894,748.05	
131	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	31,621,232,542.00	31,621,232,542.00	
			(142,113,777,248.91)	(142,113,777,248.91)	
133	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
134	АЖИЛЛАГСАД БҮГД	65	61	-4	93.8
135	Удирдах ажилтан	1	1	-	100.0
136	Гүйцэтгэх ажилтан	56	56	-	100.0
137	Үйлчлэх ажилтан	8	4	-4	50.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянгол дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь ажил олгогч, даатгуулагчийн төлсөн шимтгэл болон хуульд заасан бусад эх үүсвэрээр нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг бүрдүүлж, даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох үйл ажиллагааг эрхэлдэг, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яамны харьяа байгууллага юм.

Нийгмийн даатгалын байгууллагын зорилт нь нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн орлого зарлагын гүйцэтгэлийг ханган хяналт тавих, даатгалын сангаас тухайн төрлийн тэтгэвэр тэтгэмж төлбөрийг тогтоож, хууль тогтоомжоор тогтоосон хугацаанд олгох, нийгмийн даатгалын тогтолцоо үйл ажиллагаа, түүний арга хэлбэрийг боловсронгуй болгох талаар судалгаа хийх, санал боловсруулж шийдвэрлүүлэх, даатгуулагчдад нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах, ач холбогдлыг ойлгуулан таниулах замаар хамралтыг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын ажилтнуудын мэргэшлийг дээшлүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах харилцааг зохицуулахад оршино.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус хэлтэс үйл ажиллагаандаа Нийгмийн даатгалын багц хуулиуд, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулиудыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 239 дүгээр тогтоол;
- Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн “Нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 237 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн “Итгэлцүүр шинэчлэн тогтоох, тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 238 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 243 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 236 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” 240 дүгээр тогтоол ;
- Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоол;
- Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн “Журам батлах тухай” 361 дүгээр тогтоол;
- Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 416 дугаар тогтоол;

- Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” 415 дугаар тогтоол;
- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас даатгуулагч эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон төлбөрийг олгох, санхүүжүүлэх журам; -Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн “Журам батлах тухай” 422 дугаар тогтоол;
- Даатгуулагч тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэмж олгохтой холбогдсон бусад харилцааг зохицуулсан журам; -Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн “Журам батлах тухай” 438 дугаар тогтоол;
- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж тогтоолгоход бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэвэр, тэтгэмж олгох журам-Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 439 дүгээр тогтоол;
- Тэтгэвэр тогтоолгох, тэтгэврийн хэмжээг өөрчлөхөд бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэвэр олгохтой холбогдсон бусад харилцааг зохицуулсан журам; Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн “Журам батлах тухай” 450 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн “Тогтоол хүчингүй болгох тухай” 440 дүгээр тогтоол;
- Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн “Нийгмийн даатгалын шимтгэл төлөх журам” 470 дугаар тогтоол.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудит, мониторингийн газар 2023 онд тус хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, сангийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус хэлтэс Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн А/64 дүгээр тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, сангийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 278,439.7 мянган төгрөгөөр буюу 0.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1.0	2.0	3=2-1
Мөнгөн хөрөнгө	24,035,894.7	31,621,232.5	7,585,337.8
Авлага	88,894,817.0	81,113,586.1	(7,781,230.9)
Бараа материал	21,203.9	19,565.1	(1,638.8)
Үндсэн хөрөнгө	2,157,609.4	2,076,701.6	(80,907.8)
Нийт хөрөнгө	115,109,525.0	114,831,085.3	(278,439.7)
Өр төлбөр	1,747,783.0	3,805,189.8	2,057,406.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	113,361,742.0	111,025,895.5	(2,335,846.5)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	115,109,525.0	114,831,085.3	(278,439.7)

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс дараах өөрчлөлт гарсан байна. Үүнд: Мөнгөн хөрөнгө данс- өмнөх оноос 7,585,337.8 мянган төгрөгөөр өсөж, 31,621,232.5 мянган төгрөг болсон байна.

Авлага данс- өмнөх оноос 7,781,230.9 мянган төгрөгөөр буурч 81,113,586.1 мянган төгрөг болсон байна. Авлага дансны үлдэгдэлд төлбөртэй үйлчилгээний 49,422,250.5 мянга, татаас санхүүжилтийн 31,352,212.2 мянга, хувь хүмүүсээс авах 339,123.3 мянган төгрөгийн авлага тус тус байна. Авлагын 60.9 хувийг ажил олгогч даатгуулагчдаас авах шимтгэлийн төлбөр эзэлж байна. Тус хэлтэст бүртгэлтэй ажил олгогчдын мэдээллийг үзэхэд 50-60 хувь нь 1-30 даатгуулагчтай гэр бүлийн хамаарал бүхий компаниуд, улс орны хэмжээнд эдийн засгийн хүндрэлтэй байдал бүрэн арилаагүй зэрэг нь шимтгэлийн өр өсөх шалтгаан болсон байна.

Бараа материал данс -тайлант онд худалдан авсан 49,284.4 мянга, үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 6,357.0 мянга, нийт 55,641.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, 57,280.1 мянган төгрөгийн зарлага гарч дансны үлдэгдэл 19,565.1 мянган төгрөг болж өмнөх оноос 1,638.8 мянган төгрөг буюу 7.7 хувиар буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс- тайлант онд 6,911.5 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил шилжүүлэн авч, ТӨБЗГ-ын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 809 дүгээр тогтоолоор элэгдлээрээ өртгөө нөхсөн цаашид ашиглах боломжтой 80,778.5 мянган төгрөгийн өртөг бүхий 28 ширхэг хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг 16,155.7 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоож, ТӨБЗГ-ын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 826 дугаар тогтоолоор 7,916.4 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, эд хогшил акталж данснаас хассанаар дансны үлдэгдэл 2,533,518.0 мянган төгрөг болж, 65,627.80 мянган төгрөгөөр буурсан байна.

Тайлант хугацаанд 103,975.0 мянган төгрөгийн элэгдэл байгуулж, үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлттэй холбоотой хуримтлагдсан элэгдэлд 88,695.0 мянган төгрөгийн хасагдах өөрчлөлт орсноор үндсэн хөрөнгийн үлдэгдэл өртөг 2,076,701.6 мянган төгрөг болсон байна.

Өр төлбөр данс- өмнөх оноос 2,057,406.9 мянган төгрөгөөр өсч 3,805,189.8 мянган төгрөг болсон байна. Өглөг дансны үлдэгдэлд бараа, үйлчилгээний зардлын өглөг 734,193.4 мянга, урьдчилж орсон орлого 3,070,996.4 мянган төгрөг тус тус байна. Бараа, үйлчилгээний зардлын өглөг нь Программын шинэчлэлттэй холбоотойгоор шинээр эрх үүссэн, олгохоор хүлээгдэж буй тэтгэвэр, тэтгэмжүүд, мөн 2023 оны 12 сарын 31-ний өдөр төвлөрсөн харилцахад орсон 5 санд хуваарилах хүүгийн өглөг байна. Өглөгийн 80.7 хувийг ажил олгогч даатгуулагчид, сайн дурын даатгуулагчдын урьдчилж төлсөн шимтгэлийн төлбөр эзэлж байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/данс- тайлант оны үр дүнгийн 2,181,753.6 мянга, өмнөх оны үр дүн рүү бичсэн 154,093.0 мянган төгрөгийн залруулгын дүнгээр тут тус буурсан өөрчлөлт орсон байна.

Залруулга нь 52 даатгуулагчийн өргөдлийн дагуу үндсэн ажил олгогчоос гадна нэг буюу түүнээс дээш байгууллагад ажиллан илүү төлсөн шимтгэлийн буцаалт 114,171.9 мянган төгрөг, Улсын байцаагчийн тогтоосон 1 тэтгэвэр авагчийн 39,921.1 мянган төгрөгийн акт БГД-ийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрээр хүчингүй болсонтой холбогдон гарсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны урсгал зардлын төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,162,603.7 мянган төгрөг, нийт зарлагыг 2,162,603.71 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын сангийн төсвийн төсөөлөлд сангийн орлого төвлөрүүлгийг 330,225,227.9 мянга, зарлагыг 312,971,825.4 мянган төгрөг, орлого зарлагын зөрүүг 17,253,402.5 мянган төгрөг байхаар тус тус тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Урсгал зардлын санхүүжилтийн төсвийн төслийн саналаас цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 332,807.6 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 56,501.2 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 36,430.0 мянга, хангамж, бараа материалын зардлыг 33,640.9 мянга эд хогшил, урсгал засварын зардлыг

30,689.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 93,919.7 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 3,150.0 мянга, бусад урсгал шилжүүлгийн зардлыг 161,721.3 мянган төгрөгөөр тус тус бууруулж, 1,413,744.0 мянга, нийгмийн даатгалын сангийн орлого төвлөрүүлгийг 95,512,816.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 425,738,043.9, зарлагыг 27,517,702.4 мянган төгрөгөөр бууруулж 285,454,123.0 мянган төгрөгөөр тус тус баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

НДҮЗ-ийн 2023 оны 07дугаар сарын 05-ны өдрийн 5 дугаар тогтоолоор тайлант оны урсгал үйл ажиллагааны батлагдсан төсвийг 479,574.7 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын сангийн орлого төвлөрүүлгийг 32,940,999.8 мянга, зарлагыг 39,607,408.1 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж тодотгосон байна. НДҮЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 14 дүгээр тогтоолоор урсгал үйл ажиллагааны тодотгосон төсвийг 20,000.0 мянга, нийгмийн даатгалын сангийн орлого төвлөрүүлгийг 1,515,096.2 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, зарлагыг 200,000.0 мянган төгрөгөөр бууруулж дахин тодотгосон байна.

Тодотголоор Нийгмийн даатгалын сангийн орлого төвлөрүүлэг 460,194,139.9 мянга, зарлага 324,861,531.1 мянган төгрөг байхаар байна.

Гүйцэтгэлээр 470,546,271.7 мянган төгрөгийн орлогыг санд төвлөрүүлж, төлөвлөгөөг 2.2 хувиар давуулан биелүүлсэн байна. Тайлант онд 319,140,020.3 мянган төгрөгийг зарцуулж төлөвлөгөөнөөс 7,634,829.5 мянган төгрөгийг дутуу зарцуулсан байна.

Хүснэгт 2. Нийгмийн даатгалын сангийн орлого төвлөрүүлэг, зарцуулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биел элт
САНГУУДЫН НИЙТ ЭХ ҮҮСВЭР	460,194,139.9	470,546,271.7	10,352,131.8	102.2
Аж ахуйн нэгжээс төлсөн шимтгэл	205,090,653.4	217,091,831.2	12,001,177.8	105.9
Ажиллагсадаас төлсөн шимтгэл	169,208,655.6	172,821,597.6	3,612,942.0	102.1
Сайн дурын даатгуулагчаас төлсөн шимтгэл	19,017,336.7	13,834,680.0	(5,182,656.7)	72.7
Эхийн хvvхэд асрах чөлөөтэй хугацааны тэтгэмжийн сангаас төлөх шимтгэл	724,894.4	283,002.8	(441,891.6)	39.0
Эхийн хvvхэд асрах чөлөөтэй хугацааны улсын төсвөөс төлөх шимтгэл	254,901.5	221,292.8	(33,608.7)	86.8
ҮОМШӨДС-аас төлсөн шимтгэл	110,547.3	77,371.3	(33,176.1)	70.0
Бусад орлого	342,305.6	771,650.6	429,345.0	225.4
Улсын төсөв	65,444,845.4	65,444,845.4	-	100.0
САНГУУДЫН ЗАРЛАГА	326,774,849.8	319,140,020.3	(7,634,829.5)	97.7
Тэтгэврийн даатгалын сан	285,915,491.4	278,034,553.7	(7,880,937.7)	97.2
Тэтгэмжийн даатгалын сан	26,627,193.9	24,592,533.2	(2,034,660.7)	92.4
ҮОМШӨ-ний даатгалын сан	2,135,915.1	1,987,482.5	(148,432.6)	93.1
Ажилгүйдлийн даатгалын сан	10,182,930.7	14,525,450.9	4,342,520.2	142.6
САНГУУДЫН ТЭНЦЭЛ: - АШИГ	133,419,290.1	151,406,251.4	17,986,961.3	113.5

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,913,318.7 мянган төгрөгийг улсын төсвөөс олгохоор байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,913,318.7 мянган төгрөгийн санхүүжилт урсгал үйл ажиллагааны санхүүжилтэд олгосон байна.

Урсгал зардлын төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,810,227.5 мянган төгрөг буюу 94.6 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 83,953.8 мянга, Урсгал шилжүүлэг зардлыг 19,136.40 мянган, тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71901 Хөдөлмөр нийгмийн хамгаалал	1,913,318.7	1,810,227.5	(103,091.2)	94.6
1.1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	1,868,047.7	1,784,093.9	(83,953.8)	95.5
1.2	80102-Урсгал шилжүүлэг	45,270.0	26,133.6	(19,136.4)	57.7
	Дүн	1,913,317.7	1,810,227.5	(103,090.2)	92.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны хуулиудын хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2024 оны 1 дүгээр сарын 15-наас 2 дугаар сарын 20-ны хооронд Аккаунт траст аудит ХХК-ийн ахлах аудитор Ч.Замбага, аудитор Р.Цогзолмаа, туслах аудитор П.Саранчимэг нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер Д.Эрдэнэтуяа, компанийн захирал П.Наранцэцэг нар анхан шатны чанарын хяналтыг, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн аудитын менежер С.Гантөгс, хэлтсийн дарга Х.Түвшинбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Эрдэнэжаргал нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Нийслэл дэх Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 118 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын 470,357,739.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 7,055,366.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор НДЕГ-ын 2023оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 01/1081 тоот албан бичгээр харьяа байгууллагуудын төсвийн захирагч нарт байгууллагын хангамж болон үйл ажиллагаанд тавих хязгаарлалтуудыг мөрдөж, хэмнэлтийн горимыг баримтлан, ажиллах чиглэл өгсөн байна. Тус хэлтэс Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалт, хэмнэлтийн горимыг баримтлан ажиллаж батлагдсан үйл ажиллагааны зардлыг 103,091.2 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд 171 мэдээг мэдээлэхээс 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 194,456.5 мянган төгрөгийн 9 гүйлгээг, орлогын 289,208.9 мянган төгрөгийн 13 гүйлгээг тус тус мэдээлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийг мөрдөн ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шилэн дансны хуулийн хэрэгжилтэй холбоотой зөрчил илрүүлж, зөрчлийг аудитын тайланд тусгалаа.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 84,209.2 мянган төгрөгийн зөрчилд 6 зөвлөмж өгснийг 100 хувь хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
	6	84,209.2	6	84,209.2	100
Нийт дүн	6	84,209.2	6	84,209.2	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчил илрээгүй.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 8 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсанд 171 мэдээг мэдээлэхээс 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 194,456.5 мянган төгрөгийн 9 гүйлгээг, орлогын 289,208.9 мянган төгрөгийн 13 гүйлгээг тус тус мэдээлээгүй байна.	1	483,665.4	-	-			1	483,665.4
Дүн	1	483,665.4	-	-			1	483,665.4